

Доктор (Ph.D), дэд профессор Б.Дагзмаа

Доктор (Ph.D), профессор М.Отгонбаяр

МУИС-ийн Философийн тэнхим

ФЕМИНИСТ ФИЛОСОФИЙН ПОСТСТРУКТУРАЛИСТ УГ СУРВАЛЖ

Түлхүүр үг: феминизм, жендер, хүйс, экзистенци, субъектив чанар, бэлгийн мэдрэмж, маргиналь байдал, зохиогч, децентрац, бие, биежсэн байдал.

Феминизм бол эмэгтэйчүүдийг нийгэмд ялгаварлан гадуурхахын эсрэг тэмцэгч хөдөлгөөний ерөнхий нэр юм. Энэ нь эмэгтэйчүүдийн уг чанарын тухай, эмэгтэйчүүдийн оршихуйн онцлогийн тухай, эмэгтэйчүүдийн нийгмийн үүргийн тухай, гэр бүлийн түүхэн хэлбэрүүдийн тухай, соёл ба эмэгтэйчүүдийн амьдралын туршлага хоёрын харилцааны тухай зэрэг нийгэм-хүмүүнлэгийн ухааны янз бүрийн салбарын, түүний дотор философийн олон асуудлыг төрүүлж иржээ.

Анх Олимпии де Гужийн “Эмэгтэйчүүд болон эмэгтэй иргэдийн эрхийн деклараци” /1792/, Т.фон Гиппель-ийн “Эмэгтэйчүүдийн иргэний эрхийг сайжруулах тухай” /1792/ зэрэг бүтээлд феминист санаанууд яригдсан гэдэг. Мөн “банзалтай суутан” хэмээн алдаршсан М.Уолстонкрафт “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах нь” /1792/ бүтээлдээ эмэгтэйчүүдийн амьдралын туршлагыг рациональ соёлд багтаах тухай, эмэгтэйчүүдийн боловсролын системийн хор хөнөөлийн тухай ярьж, хүнийг хүйсийн ялгаанаас нь хамаарахгүйгээр үнэлдэг байх ёстой гэж үзэж байв. Эдгээр бүтээлд эмэгтэйчүүдийн тэгш эрхийн тухай асуудлыг анх хөндсөн нь хүний нийгмийн уг чанарын тухай гэгээрүүлэх үзэл, хүүхдийн төлөвшилд хүмүүжлийн үүргийн тухай үзэл, улс төрийн либерализм зэрэгт чухал нөлөө үзүүлжээ.

К.Марксын “Еврейн асуудалд” /1843/, Ф.Энгельсийн “Гэр бүл, хувийн өмч, төрийн үүсэл” /1883/, Август Бебелийн “Эмэгтэйчүүд ба социализм” /1879/ зэрэг бүтээлд эмэгтэйчүүдийн асуудлыг нийгмийн аливаа төрлийн (боолчуудыг, еврейчүүдийг, пролетари нарыг гэх мэт) ялгаварлан гадуурхах

үзэлтэй адилтгаад, хүнийг нийгмийн дарлалаас чөлөөлөх тухай асуудлыг тавьжээ.

Кондорсе хүйсийн тэгш байдал, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд адил боловсрол хүмүүжил олгох тухай ярьж байлаа. Английн философич Дж.С.Милль 1867 онд парламентад эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийн асуудлыг анх удаа албан ёсоор дэвшүүлж үг хэлсэн аж. Тэрээр "Чөлөөт байдлын тухай" хэмээх бүтээлээ өөрийн эхнэртэйгээ хамтран бичиж, гэр бүл болон нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил тэгш эрхтэй байх ёстой хэмээн тууштай сурталчилж байв. "Хуулийн нэр барин нэг нь нөгөөгөө захирдаг хүйсүүдийн нийгмийн харилцаа нь уг чанартаа сайн зүйл биш бөгөөд энэ нь хүн төрөлхтний дэвшлийн замд гол саад болж байна, үүнийг бүрэн тэгш байдлаар халах ёстой гэдэгт би итгэлтэй байна" гэж бичжээ. Тэрээр "Эмэгтэйчүүдийн дарлагдсан байдал" хэмээх өгүүлэлдээ: "эмэгтэйчүүдийн уг чанар" гэдэг бол зохиомол, түүхэн зүйл бөгөөд тэдний шоовдорлогдмол /маргиналь/ байдал нь эрэгтэйчүүдийн зан төлөвийн үр дүн мөн, энэ асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх ёстой гэжээ.

Эмэгтэйчүүдийн асуудлаархи үзэл санааны ийм хөдөлгөөн нь аажимдаа нийгэм улс төрийн холбогдох зохион байгуулалтууд үүсэж эхлэхэд хүргэжээ. Улмаар 1878 онд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын конгрессыг зохион байгуулжээ. Энэхүү хөдөлгөөний үр дүн болон анх 1893 онд Шинэ Зеландид эмэгтэйчүүдэд бүх эрхийг олгосон бол Финляндад 1906 онд, Норвегид 1907 онд, Австралид 1908 онд, Англид (явцуу хүрээнд боловч) 1918 онд, Америкт Колорагод 1896 онд, 1933 он гэхэд 19 штатад эмэгтэйчүүдэд сонгуулийн эрх оногджээ.

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөн 2 үндсэн үе шатаар өрнөсөн ажээ. Үүнд: 1. 19-р зууны дунд үеэс 20-р зууны 60-аад оны үед эмэгтэйчүүд тэгш эрхийнхээ төлөө, ялангуяа улс төрийн эрх буюу сонгуулийн эрхийн төлөө тэмцжээ. 2. 1960-аад оны төгсгөл 1970-аад оны эхээс "ялгаатай тэгш байдал" хэмээх уриан дор эмэгтэйчүүдийн хөдөлгөөн дахин сэргэж шинэ үе шатанд гарчээ. Энэ үед эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь нам гүм байдлаасаа сэргэж эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хэлбэрийн төдий байдлаас гаргаж нийгмийн амьдралын бодит зүйл болгохын төлөө тэмцэх болсон.

Орчин үед эмэгтэйчүүдийн асуудлыг судалдаг тусгай академик судалгаа /women's studies/ үүсэн, эл асуудлыг эрхэлдэг факультет, тэнхим,

төвүүд олноор байгуулагдан ажиллаж байна. XX зууны 90-ээд оноос нийгэмтүүхийн тодорхой нөхцөл байдал дахь хүйсүүдийн харилцааны асуудлыг судалдаг "жендерийн судалгаа" /genderstudies/ хэмээх салбар ухаан үүсэн хүчтэй хөгжиж байна. Энэ нь феминистүүдийн үзэл санаа, тэмцлийн шууд үр дагавар юм.

Эмэгтэйчүүдийг чөлөөлөх хөдөлгөөн /Women's liberation/ -д либераль, радикаль, социалист, марксист гэсэн чиглэлийн үзлүүд давамгайлж юм. Либераль феминизм нь хуучин патриархат системийг эрс өөрчлөхгүйгээр зөвхөн хүйсүүдийн хөдөлмөрийн хуваарийн ялгааг өөрчлөх байдлаар эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангана, хүйсэнд үндэслэсэн хөдөлмөрийн хуваарь алдагдах нь андрогин хэв маягийн нийгмийг төлөвшүүлнэ гэж үздэг.

Гэтэл радикаль феминистүүд нийгмийн патриархат бүтцээс болон эрэгтэйчүүдээс ялгаатай эмэгтэйчүүдийн оршихуйг нөхцөлдүүлдэг тийм нийгмийн дэг журмыг тогтоохын төлөө байдаг. Эмэгтэйчүүдийг эх болохынх нь хувьд нь болон бэлгийн харилцаагаар дарамталдаг гол хэрэгсэл бол гэр бүл мөн гэж тэд үздэг. Тэд бэлгийн харилцааны чөлөөт байдал, эх болохоос татгалзах, жендерийн аливаа ялгааг өөрчлөх зэрэг асуудлыг хөндөж "эрчүүдийн шовинизм"-ийн эсрэг "эмэгтэйчүүдийн хувьсгал" хийхийг сурталчилдаг.

Социалист феминизм нь эмэгтэйчүүдийн асуудлыг ангийн болон арьс өнгөний ялгаварлан гадуурхахтай адилтган үздэг бөгөөд эдгээр асуудлыг шийдвэрлэвэл мөн хүйсээр ялгаварлан гадуурхах нь устана хэмээдэг.

1960-аад оноос либераль феминизм дахин сэргэхдээ эмэгтэйчүүд засаглалд тэнцүү төлөөлөлтэй байх, боловсролд тэнцүү эрхтэй байх, хөдөлмөрийн хуулийг дахин боловсруулах зэрэг саад бологч нийгмийн хэвшмэл сэтгэлгээтэй тэмцэхийг нийгмийн тэмцлийнхээ бодит объект болгосон юм. Тухайлбал америкийн феминист эмэгтэй Бетти Фриден 1963 онд хэвлүүлсэн "Бүсгүй хүний шидэт нууц /The Feminine Mystique/" хэмээх бүтээлдээ америк эмэгтэйчүүдийн ухамсрыг судлан шинжлээд эмэгтэйчүүдийн хувь хүний адилсал /identity/ нь эрэгтэйчүүдийнхээс эрс ялгаатай байдаг бөгөөд эмэгтэйчүүд хүн болох хувьдаа өөрсдийн хүч нөөцийг хэрэгжүүлэх, тулгуур хэрэгцээгээ хангах боломжийг манай соёл олгохгүй

байна. Иймээс эмэгтэйчүүд бол нийгмийн ялгааны үзлийн золиос болдог гэсэн дүгнэлтийг хийжээ.

Энэ үеэс феминизмийн ном зохиолын үер бууж эхэлсний дотор феминист философийн ном зохиолууд жинтэй байр суурьтай юм.

* * *

Нийгэм дэх хүний статус бол түүний эдийн засаг, улс төрийн амьдралд оролцох байдал, оршин буй засаглалын систем дэх оролцоо болон хөдөлмөрийн үр дүн болох өмчид тавих хяналт зэрэг хүчин зүйлсээр тодорхойлогддог. Ийм ч учраас феминизмийн онолуудад нийгэм дэх эмэгтэй хүний шоовдор байдлыг дан нийгэм, эдийн засгийн нөхцөлүүдээр тайлбарладаг.

Гэтэл орчин францын алдарт философич Симона де Бовуар (1918-1986) дээрх байдлыг эмэгтэй хүний сэтгэл зүйтэй холбож үзсэнээрээ онцлог юм. Ингэхдээ тэрээр эмэгтэйчүүдийн нийгэм-соёл дахь дагавар байдал нь хувь хүний сэтгэл зүйн хүрээнд, хувь хүний үл ухамсарлахуйн түвшинд гүнзгий нэвтэрсэн учраас үүнийг судалснаар л соёл дахь эмэгтэйчүүдийн байр суурийн асуудлыг тавьж болно гэж үзжээ.

Мөн түүний үзлээр ертөнцөд өөрийн үнэлэмжийг тогтоохыг оролдогч субъект нь ямагт “өөрийн бэлэн ахуйн” хүрээнээс халисан трансцендент байр суурьтай байдаг /энд хүн энгийн объект төдий байдаг/. Нийгэм соёл дахь эмэгтэйчүүдийн статусын асуудал нь ямагт хоёрдмол байдлаар үнэлэгддэг. Тухайлбал эсвэл эмэгтэйчүүдийг бүрэн үгүйсгэх, эсвэл эмэгтэйчүүдийн уг чанарт өгөгдмөл биш шинжүүдийг тэдэнд нялзаахыг оролддог. Иймээс тэрээр соёл дахь засаглал ба эмэгтэй хүн хоёрын харилцааны асуудлыг “ондоон” хэмээх ойлголтоор дамжуулан тайлбарлажээ.

Эмэгтэйчүүдийн экзистенци нь эрэгтэйчүүдийнхээс эрс ялгаатай учраас түүхэнд дан эрчүүд л өмчийн төлөө тэмцэж ирсэн юм. “Хувийн өмч үүссэнээр эмэгтэйчүүд засаглалаас бүрэн холдсон бөгөөд олон зууны туршид эмэгтэйчүүдийн хувь заяа хувийн өмчтэй холбоотой байсан, тухайлбал өв залгамжлалын түүхтэй эмэгтэйчүүдийн түүх төстэй юм”¹ хэмээн Симона де Бовуар үзжээ. Ийнхүү Симона де Бовуар эмэгтэй хүний нийгмийн статусын

¹ Симона де Бовуар. Второй пол /пер с француз. М.:2000. С 112.

асуудлыг зөвхөн үйлдвэрлэл болон улс төрийн явцуу хүрээнд биш, харин соёлын өргөн орчинд дэвшүүлсэн юм.

Эмэгтэйчүүдийн нийгэм дэх социаль үүргийн хуваарилалт нь тэдний биологи төдийгүй эмоци-сэтгэцийн байдалтай холбоотой тодорхойлогддог учраас эрчүүдийн тогтоосон ёс суртахуун болон нийгмийн тогтолцоонд эмэгтэйчүүд нь "ондоо" зүйл юм. "Эмэгтэй хүн болж төрдөггүй харин эмэгтэй хүн болдог" гэсэн дүгнэлтийг эмэгтэй хүний (охин, бүсгүй, ээж гэсэн) насны есөлтийн явцад нь түүний бие организмд болон бие хүний хувьд гардаг өөрчлөлтүүдийг авч үзэж судалсны үндсэн дээр Бовуар хийжээ. Энэ эрэгтэй эмэгтэй хүний дээрх социаль үүргийн хуваарилалт дахь хүнийслийн асуудлыг мэдэрсний үр дүн биз.

Феминизмийн аль ч хувилбарт нийтлэг байдаг нэг утга санаа бол хүний нийгмийн соёл нь өөрийн уг чанараараа патриархат буюу эрчүүд давамгайлсан, эрчүүдэд хандсан үйл бүхий байдаг. Төрөх үүргийг гүйцэтгэдэггүй тэр зүйлд л байдаг чанарууд болох чөлөөт байдал, идэвхит шинж, эрх мэдэл, бие даасан, хараат бус байдал, хүч чадал, эр зориг гэх мэтийг жинхэнэ хүний шинж хэмээн үнэлдэг тийм нийгмийн бүтэц соёлд тогтсон юм. Энэ бүтэцэд эмэгтэй хүн бол дагавар зүйл байдаг. Иймээс ч Дж.Стюарт Милль: "нийгмээс эмэгтэйчүүдийг хүүхэд төрүүлдэг гэдгээр нь далимдан дарамталж байдаг" гэжээ. Ийм соёл дахь хүн бол хэрэг дээрээ "эрэгтэй хүн" гэдэг ойлголттой адил утгатай. Тийм ч учраас "Хүн бол төр улсын амьтан" (Аристотель), "улс төрийн зүйл" (Гоббс), "эрх чөлөөт зүйл" (Руссо), "рациональ зүйл" (Кант), "өөрийн чөлөөт дур зорго бүхий зүйл" (Фихте), "хөдөлмөрийн хэрэгслийг бүтээдэг амьтан" (Франклин) гэх мэт тодорхойлолтуудад чухамхүү эрэгтэй хүнийг л дүрсэлсэн гэмээр байдаг. Гэтэл эмэгтэйчүүд нь иррациональ, эмоциональ, мэдрэмтгий, сул дорой, хараат, бие даасан биш гэх мэт эрчүүдийн эсрэг шинжийг хадгалж байдаг гэгдэн нийгмийн амьдралаас шахагдан ар талын, орон гэрийн, дагавар зүйл болон үнэлэгдэх болсон.

Аристотель: "Эмэгчин амьтад бол тодорхой чанарууд байдаггүй учраас л эмэгчин болдог, эмэгтэйчүүдийн араншин нь байгалийн гэм нүглээс болж шаналж байгаагаас болдог", Августин: "Эмэгтэйчүүд бол тогтворгүй, бат бэх биш амьтан, хашаа саравчгүй амьтан", Аквины Фома: "Эмэгтэйчүүд бол эрэгтэй болж чадаагүй азгүй амьтад", Тертуллиан: "тамын хаалга мөн" гэх

мэтээр тодорхойлж байжээ. Гегель эмэгтэйчүүдийг ерөөс хүний зүйлд тооцохгүй байх хэрэгтэй гэжээ.

Энэ байдал нь шашин, шидэт домгийн үзэлд ч бат суурьтай байдаг.

Эмэгтэйчүүдэд өгдөг эдгээр аягийн үнэлгээнээс үүдэн оюуны ба биеийн зүйлийн харьцаа, засаглал, субъектив чанар, шинжлэх ухааны мэдлэгийн өвөрмөц онцлог зэрэг философи асуудал урган гарч буй юм. Феминист философичид -философийн түүхийн феминист шүүмжлэл, -ёс зүйг засварлах, -эпистемологи ба шинжлэх ухааны философийн гэсэн 3 чиглэлд онцлон асуудлыг тавьдаг.

Феминизмийн түүх- философийн дискурсад: 1. уламжлалт философи бол эрчүүдийн л зүйл мөн, 2. философи дахь хүний тухай ойлголт нь эрэгтэй хүнээр төлөөлөгддөг, 3. гарамгай эмэгтэйчүүдийн туршлагыг соёлд ердөө тооцож байгаагүй гэсэн сэдвүүдийг дэвшүүлэн тавьдаг.

Феминистүүд бие хүний эрх, бие даасан байдал, чөлөөт байдал, тэгш байдлын тухай авч үзэхдээ индивидуализмыг шүүмжилж, бусдын өмнө хүлээх хариуцлага, харилцан хамааралтай байх зэрэг асуудлыг тавьдаг "санаа тавих ёс зүй"-г индивидуализмд сөргүүлж иржээ.

Эпистемологи болон шинжлэх ухааны философид сэтгэл-бие, рациональ-эмоциональ, объектив-субъектив гэх мэт дуализмд гол анхаарлаа хандуулдаг билээ. Эдгээр эсрэгцэл нь эрчүүдийн сонирхлыг илэрхийлэгч оюуны, рациональ, объектив гэх мэт илт давамгай модаль шинж бүхий шаьталсан /иерархи/ тогтолцоо болон соёлд бүрдсэн хэмээн феминист философичид шүүмжилдэг. Иймээс ч дуалист биш, иерархи биш мэдлэгийн загварын асуудал өнөө үеийн эпистемологид хүчтэй болсон. Энд хүний туршлагыг бүх талаас нь бүхэл байдлаар нь авч үзэх ёстой. Ийм учраас туршлагын ямарч бүрдэл нь дорд, доод зүйл мэтээр яригдах ёсгүй хэмээх үнэлэмж чухал болсон юм.

Модерн болон структуралист философиос постструктуралист, постмодерн философид шилжих ХХ зууны II хагасаас хойшхи үеийн философийн хандлага нь ертөнцийг хоёрдуулан /бинар/ үүднээс авч үздэг уламжлалт дихотомид байгууламжийг өөрчлөх гэсэн үзэл санааг төрүүлсэн юм. Үүний үр дүнд нэгж ба ерөнхий, бодгаль хүн ба нийгэм, бололцоо ба бодит байдал, интуитив ба рациональ чанар, объектив ба субъектив, эрэгтэй ба эмэгтэй гэх мэт уламжлалт философи дахь хоёрдмол эсрэгцүүллийг

өөрчлөх замаар философи сэтгэлгээний шинэ хэв маягийг төлөвшиж байна. Францын философич Мерло Понти: “XX зууны метафизикийн хамгийн чухал зорилт бол философийн мөнхийн асуудлуудыг дэвшүүлэн гаргаж ирэх болон тэдгээрт хариулт өгөх аль алинд нь эсрэгцүүлэх /антитетик/ байдлыг даван туулах явдал мөн” хэмээн тодорхойлжээ.

Эрэгтэй болон эмэгтэй гэсэн бинар харьцуулалтыг даван туулах гэсэн оролдлогын нэг илрэл нь постмодернист “дур татах” /соблазн - seduction/ гэдэг ойлголт юм. Бодрийяр: “орчлонд эмэгтэйчүүд нь эрэгтэйдээ эсрэг байдаг биш, харин түүний дурыг татаж байдаг” гэжээ.

XX зууны философи дахь асуудлыг өөрөөр тавьж, шийдвэрлэх гэсэн оролдлого, хэл болон текстийн асуудал, иерархийг арилган ялгааг илэрхийлэгч хэлийг бүтээх гэсэн оролдлого ч феминист философид хүчтэй байна. Тухайлбал Ж.Делёз хоёрдмол /моляр/ зарчмаас молекуляр хуваалтад шилжих, Р.Бартын “хүслийн тоотой тэнцүү хэлний тоо” зэрэг баримтлал боловсруулсныг дурдаж болох юм.

Постструктуралистуудын хэлний шүүмжлэл нь хэлний бүтцийн иерархи байдлыг сэргээхийн эсрэг зогсох боломжийг олгосон юм. Кристева: субъектын төлөвшил дэх семиотик үе шат нь түүнээс хожуу гарч ирдэг ухамсрын стереотип, символ зэрэгт хянагддаггүй плюралист зүйл мөн гэсэн бол, Лакан: субъектын төлөвшил дэх семиотик үе шат бол субъектив адилслын үндсэнд байдаг гэж үзжээ. Үл ухамсарлахуйн буюу биеийн илэрхийллийн талбар бол өөрийн субъектив байдлыг илэрхийлэх гол зүйл мөн гэж М.Фуко, Р.Барт нар үзсэн. Иймээс феминист постструктурализм үүсэх нэг үндэс нь семиотик анализ байсан гэж хэлж болно.

Феминист постмодернизмын хөгжилд Р.Бартын дэвшүүлсэн “зохиогчийн үхэл”, “эмэгтэй зохиолч”, “эмэгтэйчүүдийн бичлэг” хэмээх томъёоллууд чухал нөлөө үзүүлсэн ажээ. Тэрээр: “Зохиогч бол нийгмийн хүн гэдэг утгаараа шууд үхмэл болдог. Тэр иргэнийхээ хувьд ч, эмоциональ байдлаараа ч, намтар түүхтэй бие хүн гэдгээрээ ч цаашид оршихгүй: энэ хүн нь /зохиогч/ өөрийн бүтээлийн эцэг болох агуу засаглалаа алддаг”¹ гэжээ.

Р.Барт “зохиогчийн үхэл” гэдэг томъёоллынхоо утгыг нээхдээ зохиогч гэдгийн оронд “нэр зээлдэгч” гэдэг үг хэрэглэжээ. Нэр зээлдэгч бол априори байдлаар үнэнийг мэдэгч бус, учир нь үнэн бол зөвхөн уншигчийн амьдралд

¹ Р.Барт. Удовольствие от текста// Избранные работы.М.:1989.* С483.

оршиж байдаг зүйл тул уншигчгүй зохиолын утга холбогдол гэж үгүй юм. Иймд “зохиогчийн үхэл” нь “уншигчийн төрөлт” –ийг нөхцөлдүүлж, уншигчийн уламжлалт идэвхгүй үйлийг өөрчлөхөд хүргэн, зохиогчтой холбоотой текстийн явцуу утгын оронд уншигчидтай холбоотой утгын олон янз байдал үүсдэг. Ингэхлээр нэг зохиогчийн оронд уншигчийн тоогоор олон зохиогч төрж, энэ тугаар “зохиогч үхдэг”.

Текстийг уншина гэдэг бол тодорхой утгаар өөрийн амьдралыг “бичнэ” гэсэн үг хэмээх энэхүү арга зүй нь феминист философид унших явцад эмэгтэй хүн өөрийн субъектив чанарыг өөрчлөх бололцоотойг онолын хувьд үндэслэж өгсөн юм. Тухайлбал америкийн философич, зохиолч Адриенн Рич: эмэгтэй хүний уншлага нь өөрийн амьдралыг дахин ухаарч, амьдралаа патриархат соёлын стереотипуудаас гадна өөрчлөх зорилготойгоор засвар хийх явдал мөн гэжээ. Иймд аливаа патриархат текстийг зохиогчийн сэдлээс үл хамааран феминист утга оноолт хийх, дахин тайлбарлах, контекстийг өөрчлөх боломжтой гэсэн санааг өгснөөрөө Бартын үзэл феминист онолд чухал юм.

Сэтгэхүйн стереотипуудыг шүүмжлэх орчин үеийн хандлагын ерөнхий голдрилд Дерридагийн деконструктивист шүүмжлэл гол байртай юм. Түүний философийн деконструкцийн гол зорилт бол уламжлалт метафизик болон сэтгэлгээний ноёрхлын уламжлалт системийг даван туулах, “ондоо байдал”, “олон янз байдал”-ыг орчин үеийн сэтгэлгээний дискурсад хэвшүүлэх явдал юм. Тэрээр эмэгтэйг эрэгтэй эхлэлийн дагавар болгон, эмэгтэй хүний дуу хоолойг соёлын бодит текстүүдийн олон янз байдлаас шахан зайлуулдаг баримтлал бол угтаа фаллоцентрист¹ шинжтэй уламжлалт метафизик юм хэмээн шүүмжилжээ.

Деррида орчин үеийн түүхэн үзэгдлийг соёлын “децентраци” хэмээсэн. Нийгэм ба соёл дахь нөхцөл байдал нь философи ба хэлэн дэх нөхцөл байдалтай адил бөгөөд энд цөм, төв гэж байхгүй, цөмийг тойрон эргэлдэх нийгмийн амьдрал, соёл, тайлбарлал, философи үзэл гэж үгүй юм. Ийм учраас Дерридагийн үзлээр орчин үеийн сэтгэлгээний зорилт бол нэг утгатай тэмдэглэгдсэн “бэлэн байгаа одоо”-г сэтгэх биш, харин бололцоотой ч хэрэгжихгүй “ялгаа”-г сэтгэх, өөрөөр хэлбэл тэмдэг, систем, харилцааны цоо шинэ ойлголтуудын үндсэн дээр сэтгэх явдал юм. Нийгэм, соёл дахь

¹ грекийн phallos- эр хүний бэлэг эрхтэн гэсэн үг, зарим ард түмэнд байгалийг бүтээгч эхлэлийн бэлэг тэмдэг гэдэг.

эрчүүдийн давамгайл байдлыг деконструкцид оруулбал эрэгтэй, эмэгтэй хүний харилцааны асуудлыг өөр өнцгөөс харуулж, дутагдлыг нь тод томруунаар илчлэх болно гэдэг утгаар соёл дахь "ондоо байдлын" үзэгдлийг хүлээн зөвшөөрч, сэтгэхүйн уламжлалт стереотипуудыг шүүмжлэх деконструктивист хандлага нь феминист философийн бас нэгэн арга зүй болсон юм.

Эмэгтэй хүний субъектив чанарын талаархи судалгаа явуулснаараа Фрейдийн үзлийг шинэ шатанд гаргасан хүн бол Лакан юм. Түүний үзлээр эмэгтэй хүн бол уламжлалт соёлд эрчүүдийн тогтоосон утгуудыг бүрэн хүлээн зөвшөөрөх, эсвэл өөрийгөө илэрхийлэх боломжгүй байдалд орох гэсэн бинар нөхцөлд оршдог. Учир нь уламжлалт соёлд "эмэгтэй хүнийх" гэдэг дискурсууд бүрэлдэн тогтоогүй, субъектив чанар бол өөрийн үндсээрээ бүхэл биш, тодорхойлж боломгүй зүйл хэмээн үзсэн. Энэ үүднээс үзвэл эмэгтэйчүүдийн соёл бол эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад онцгой зүйл биш бөгөөд уламжлалт сэтгэлгээ, соёл хэмээн нэрлэж байсан тэр зүйлд үнэлэмж, хэм хэмжээний нэгдэл байдаггүй.

XX зууны 80-аад оноос хойш хүчтэй хөгжиж байгаа эмэгтэй хүний бэлгийн мэдрэмжийн үзэгдлийн судалгаанд М.Фуко хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Түүний бичсэн "Бэлгийн мэдрэмжийн түүх" зохиол нь феминист онолын арга зүйн цаашдын хандлагыг чиглүүлж өгсөн юм. Бэлгийн мэдрэмж, эрх мэдэл, солиорол, хүсэл, дорд үзэгдэх /маргиналь/ үйлдлүүд, субъектив чанарын хэв маягууд зэрэг бол түүний энэ бүтээлийн цөм нь билээ. Фукогийнхоор субъектив чанарын аффект нь (цухалдал) бие мөн. Өөрөөсөө хүнийсэн, өөртэйгээ адил байхаа болих нь шоовдор /маргиналь/, биежсэн субъект гэж тэрээр тодорхойлсон. Ийм маргиналь субъектив чанарын жишээ болох үзэгдлүүд бол шоронгийн хоригдол, солиотой хүн, өвчтэй хүн, улс төрийн субъект, мөн эмэгтэйчүүд, хүүхэд мөн. Фукогийн биеийн зарчим нь дарангуйллын механизм болсон эрх мэдлийн зарчимтай салшгүй холбоотой бөгөөд энэ нь субъектив чанарын бүтцийг тогтоодог байна.

Фуко "Захирах ба шийтгэх" хэмээх зохиолдоо "дарангуйлал" гэдэг ойлголтын хэлний утгыг биш, харин дарангуйллыг улс төрийн үзэгдэл болох хувьд нь судалжээ. Түүнийхээр улс төрийн дарангуйлал бол төрийн байгууллагуудын зүгээс явуулж буй үйл ажиллагаанаас хавьгүй өргөн үзэгдэл, үүнд бодгалиудад үр дүнтэй нөлөөлөх чадвар мөн аж.

Фукогийн эл үзлийг нийгэм дэх хүйсүүдийн хоорондын харилцааг тайлбарлах арга мөн гэж феминист философичид хүлээн авч нийгэм дэх субъектив чанарын жендерийн ялгаа нь үл өөрчлөгдөх биологийн ялгаа биш, харин эрх мэдлийн стратегиудын тодорхой хэв маягуудын улмаас тогтсон нийгмийн бүтээгдэхүүн мөн хэмээн дүгнэдэг. Ийнхүү феминист философичдын үзлээр орчин үеийн соёл бол дуулгаварт байдал болон ашиг тусын рациональ хэлбэрүүдийн ноёрхол билээ.

Ийнхүү орчин үеийн засаглалын үзэгдлийг судлах үндсэн хандлага нь аль нэгэн засаглалын байгууллагууд руу дайрах биш, харин нийгэмд жендерийн тэгш бус байдлыг үүсгэж байгаа засаглалын технологийг өөрчлөх явдал болжээ.

Эцэст нь дүгнэн хэлэхэд “Бүсгүй хүний шинж” /женственность, femininity/ бол өвөрмөц социопсихик шинж бөгөөд энэ нь ертөнцөд эмэгтэйчүүд өөрийн байр суурийг тодорхойлох хэрэгсэл болох ёсгүй, мөн хүйсүүдийн хоорондын засаглах харилцаанд нөхөөс болох ёсгүй. Ерөөс феминист философи бол засаглал, тэгш бус байдал, шударга ёс зэрэг асуудлаар нийгэмд тогтсон уламжлалт стереотипийг засварлах гэсэн нийгэм соёлын шинжтэй юм.

Хүний (эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн аль алины) нийтлэг уг чанарыг гаргахын тулд эмэгтэйчүүдийг жинхэнэ ёсоор чөлөөлөх ёстой. Эмэгтэйчүүдийг чөлөөлнө гэдэг бол эрчүүдийг үгүйсгэхгүйгээр түүнтэй харьцах харьцааг өөрчлөх, харилцан бие биенээ хүн хэмээн хүлээн зөвшөөрөх, харилцан бие биедээ ондоо байх ёстой.

Резюме

В данной статье авторами предпринята попытка определения источников и освещение основных проблем современной феминистской философии.

Философским источником современной феминистской философии являются экзистенциалистские положения Ж.-П.Сартра и Симоны де Бовуар, написавшей книгу под названием "Второй пол", которая оказала поистине решающую роль в развитии философского феминизма. Кроме того, авторы показали, что дальнейшее развитие феминистского движения и, в частности, формирование его основных философских положений, тесно связано со взглядами классиков постструктурализма, таких как Р.Барт, Ж.Деррида и М.Фуко.

Подытоживая статью, авторы отметили, что женственность – это социопсихическая особенность, которая не должна становиться орудием угнетения и непреходимой преградой в отношениях между полами.